



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгчийг ажлаас чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, “Монголын хөрөнгийн бирж” ХК (“Компани” гэх)-ийн “Дүрэм”-ийн 5.7.8 дахь заалтууд, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.5.4, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулсан 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн хоорондын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний 6 дугаар зүйлийн 6.1.3, 6 дугаар зүйлийн 6.2.2, Т.Хаш-Эрдэнийн 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тамираа овогтой Хаш-Эрдэнийг түүний хүсэлтээр Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлж, түүнтэй байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г 2025 оны 12 сарын 10-ны өдрөөр тасалбар болгон дуусгавар болгосугай.
2. Т.Хаш-Эрдэнийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлсөнтэй холбоотойгоор түүнийг Бизнес хөгжлийн газрын захирлын албан тушаалд эргүүлэн томилсугай.
3. Т.Хаш-Эрдэнэд Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үүрэгт ажлаа 2025 оны 12 сарын 10-ны өдрийн дотор ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээлгэж өгөхийг үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010137



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.8 дахь хэсэг, Нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дүгнэлт, Сангийн яамны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/10405 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Даваацэрэн овогтой Мөнхбатыг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтаар Гүйцэтгэх захирал томилогдох хүртэл хугацаанд компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-ийн сарын үндсэн цалинг 7,000,000 төгрөгөөр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэгч (Б.Оюун)-д зөвшөөрсүгэй.
3. Д.Мөнхбаттай байгуулах Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг өмнөх Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй ижил байдлаар байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010140



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай


Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.3, 49 дүгээр зүйлийн 49.1.2, 49.1.4, 49.3, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.22 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
 - 1.1. Журмын 4.4.5, 4.4.7, 4.5.3, 14.6 дахь заалтуудын "ногоон" гэсний ард "нийгмийн, тогтвортой байдлын" гэж нэмэх;
 - 1.2. Журмын 4.4.8 дахь заалтад "Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн "Ногоон /нийгмийн/ тогтвортой байдлын бондын танилцуулга" гэж нэмэх;
 - 1.3. Журмын 15.2.4 дахь заалтыг "Монгол Улсын "Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи" эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу "нийгмийн хөгжилд эерэг нөлөөтэй", "байгаль орчин, нийгмийн хөгжилд эерэг нөлөөтэй", "Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн" үйл ажиллагааг санхүүжүүлэх тохиолдол" болгон өөрчлөх;
 - 1.4. Журмын 21.13 дахь заалтад "Ногоон, нийгмийн, тогтвортой байдлын бонд гаргагч нь мэдээллийн ил тод байдлыг хангахдаа энэхүү журам, Бүртгэлийн гэрээ болон Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ыг баримтална." гэж нэмэх;
 - 1.5. Журмын 22.10 дахь заалтыг "Засгийн газрын үнэт цаасны хувьд үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлсний хэмжээг Бирж болон үнэт цаас гаргагчийн хооронд байгуулах гэрээгээр зохицуулж болно" болгон өөрчлөх;
 - 1.6. Журмын 22.16.7 дахь заалтыг "Монгол Улсын "Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи" эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу "нийгмийн хөгжилд эерэг нөлөөтэй", "байгаль орчин, нийгмийн хөгжилд эерэг нөлөөтэй", "Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн" үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргаж бүртгүүлэх;" болгон өөрчлөх;
 - 1.7. Журмын 22.16.9 дэх заалтад "Энэ журмын 22.16.7; 22.16.8 дахь заалтад багтах этгээд нь Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 5.2-д

1525010143

- заасны дагуу хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулсан байна.” гэж нэмэх;
- 1.8. Журмын 23.11.3 дахь заалтын “жилийн үйлчилгээний хөлсийг 2 жилээс дээш хугацаанд төлөөгүй” гэсэн хэсгийг хасах;
 - 1.9. Журмын Нэгдүгээр хавсралтын 2.2-т “Засгийн газраас гаргасан Өрийн хэрэгслийн хувьд” гэснийг “Засгийн газар, аймаг, нийслэлийн засаг даргын үнэт цаас болон олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан Өрийн хэрэгслийн хувьд” болгон өөрчлөх;
 - 1.10. Журмын Нэгдүгээр хавсралтын 2.2-т “500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс ихгүй” гэснийг “300,000,000 (гурван зуун сая) төгрөгөөс ихгүй” болгон өөрчлөх;
 - 1.11. Журмын Долоодугаар хавсралт “Бүртгэлийн гэрээ”-ний 2.1.2.1-т “500 сая төгрөгөөс ихгүй” гэснийг “300,000,000 (гурван зуун сая) төгрөгөөс ихгүй” болгон өөрчлөх, “Бүртгэлийн гэрээ”-ний 2.1.4, 2.1.5 дахь заалтыг хасах.
2. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, батламжлуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.
 3. Энэхүү журмын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжилсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
 4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР